



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 21/495

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376:2014 6.1-д зааснаар эмийн жорын хяналтыг сайжруулах, жор бичилтийг бүртгэх, жорын дагуу эм худалдан авах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор “Цахимаар эмийн жор бичих, олгох заавар”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Цахимаар жор бичих, олгох үйл ажиллагааг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Бодлого төлөвлөлтийн газрын Эрүүл мэндийн цахим мэдээллийн хэлтсийн дарга /Т.Бат-Эрдэнэ/, хэрэгжилтийг ханган ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн А/262 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн сайдын 2020 оны . . .
дугаар сарын 26-ны өдрийн . . .
дугаар тушаалын хавсралт

10
2/1995

ЦАХИМААР ЭМИЙН ЖОР БИЧИХ, ОЛГОХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү зааврыг Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.1, 15.1.2, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.9, 15.1.11, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.3-т заасан эмийн сан цахимаар эмийн жор бичих, олгоход мөрдөнө.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1 Энэ зааварт хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1. “Цахим жор” гэж “Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376:2014 стандартын 4.1 дүгээр заалтад заасан эмийн жорыг цахимаар дамжуулж буй хэлбэрийг;

2.1.2. “Цахим жорын систем” гэж цахим жорыг бүртгэх, хянах, хамгаалах, хадгалах, ашиглах, баяжуулах зориулалт бүхий Үндэсний дата төв дээр байрлах цахим системийг;

2.1.3. “Хяналтын дугаар” гэж тухайн эмийн жор бүрд цахим жорын системээс олгогдох давтагдахгүй кодыг;

2.1.4. “Цахим жорын системд нэвтрэх эрх” гэж тухайн эрүүл мэндийн байгууллагын эмч регистрийн дугаараараа цахим жорын системд нэвтэрч жор бичих эрхийг;

2.1.5. “Цахим жор бичигч” гэж цахим жорын системд нэвтрэх эрх авсан эмчийг;

2.1.6. “Админ” гэж жор бичигчид цахим жорын системд нэвтрэх эрх олгох эрх бүхий албан хаагч;

Гурав. Цахимаар жор бичих

3.1 Эмч цахим жор бичихдээ “Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376:2014 стандартыг баримтална.

3.2 Цахим жорын системд цахим жор бичигч нь иргэний бүртгэлийг регистрийн дугаараар бүртгэх ба үзлэгийн тэмдэглэлийг бичиж оруулан, оношийг олон улсын өвчний ICD-10 дугаар ангиллын кодоор тавьж, эмчилгээний үргэлжлэх хугацааг сонгон системээс эмийг олон улсын ерөнхий нэршлээр тун хэмжээг сонгож тоо ширхгийг бичнэ.

3.3 Эмч цахим жорыг өөрийн болон иргэний хурууны хээгээр баталгаажуулна.

3.4 Эмч урт хугацаанд эмчийн хяналтанд уух эмийн жорыг 3 сар хүртэлх хугацаагаар бичнэ.

3.5 Гадаад улсад 3 сараас дээш хугацаанд зорчих нь нотлогдсон тохиолдолд урт хугацаанд уух эмийн жорыг бичихдээ тун хэмжээ, тоо ширхгийн дагуу хамгийн ихдээ 6 сарын турш хэрэглэхээр бичиж болно.

3.6 Сэтгэцэд нөлөөт эмийг цахимаар бичих ба MNS 5376:2014 стандартын 5.7-д заасан маягтыг ашиглан давхар бичиж, хяналтын дугаарыг жорын доод хэсэгт эмчийн гарын үсгийн дээд талд бичнэ.

3.7 Цахим хэлбэрээр бичсэн эмийн жорыг иргэний хүсэлтийн дагуу жорын маягт дээр бичиж өгч болох ба хяналтын дугаарыг жорын доод хэсэгт эмчийн гарын үсгийн дээд талд бичнэ.

3.8 Цахим жорын хяналтын дугаарыг амбулаториор үйлчлүүлэгчдийн картанд тухайн өдрийн үзлэгийн тэмдэглэл хэсэгт эмийг олон улсын ерөнхий нэршил, тун хэлбэр, хэрэглэх зааврын хамт бичнэ.

3.9 Цахим жор бичигч нь 0-16 насны хүүхдийн жор бичихдээ асран хамгаалагчийн хурууны хээгээр баталгаажуулах.

3.10 Хурууны хээ нь танигдахгүй иргэдийн мэдээллийг цахим жорын систем дэх сангаас иргэний үнэмлэхээр баталгаажуулах.

3.11 Цахим жор бичигч нь хөдөлмөрийн гэрээнд тусгасан ажлын байрны чиг үүргийн хүрээнд жорыг бичнэ.

Дөрөв. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үүрэг

4.1 Цахим жорын системийн тогтвортой үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангана.

4.2 Эмийн бүртгэл, эм баркодтой байх үйл ажиллагааг бүрэн хариуцна.

4.3 Эрүүл мэндийн салбарын байгууллагуудыг цахим жорын систем ашиглах арга зүйгээр хангана.

4.4 Цахим жорын системээс эмийн бүртгэл, статистикийн үзүүлэлтийг гаргана.

Тав. Эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг

5.1 Энэхүү зааврыг мөрдөх эрүүл мэндийн байгууллага нь цахим жор бичигч болон иргэний мэдээллийг баталгаажуулах хурууны хээ уншигч төхөөрөмжтэй мөн интернет сүлжээнд холбогдсон байна.

5.2 Эрүүл мэндийн байгууллага нь цахим жор бичигчид цахим жорын системд нэвтрэх эрхийг олгох, хаах, сэргээх, шилжүүлэх, цуцлах зэрэг зохицуулалтыг хариуцах админтай байна.

5.3 Эмнэлгийн удирдлага цахим жорын системд нэвтрэхэд эрх олгосон эмчийг эрхээ бусдад дамжуулан ашиглуулахгүй, зүй бусаар ашиглахгүй, хувь хүний нууцыг задруулахгүй байхад хяналт тавьж, хариуцлага хүлээнэ.

5.4 Эрүүл мэндийн байгууллага, цахим жорын системд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийн тайланг нэгтгэн жил бүрийн 01 дүгээр сарын 15, 07 дугаар сарын 15-ны дотор Эрүүл Мэндийн хөгжлийн төвд хүргүүлнэ.

Зургаа. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үүрэг

6.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэхээр батлагдсан эмийн жагсаалтын дагуу санхүүжилтийг тооцох үйл ажиллагааг зохион байгуулна.

6.2 Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь Админ болон тухайн эрүүл мэндийн байгууллагын даргатай “Хэрэглэгчийн нууцлал, аюулгүй байдлын гэрээ” байгуулж, цахим жорын системд нэвтрэх зохицуулалтыг хариуцах Админ эрхийг олгоно.

6.3 Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалтыг шинэчлэн батлагдах тухай бүрд эмийн нэр, үнэ, хөнгөлөлтийн хувь хэмжээг цахим жорын системд шинэчлэн оруулна.

6.4 Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь хөнгөлөлттэй эм олгох үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтыг ЭМД-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.7 дахь заалтыг үндэслэн хийнэ.

Долоо. Аймаг, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын үүрэг

7.1 Цахим жорын систем хэрэглэх талаарх сургалт зохион байгуулж, тогтвортой үйл ажиллагааг хангана.

7.2 Журмын 1.1-д заасан эрүүл мэндийн байгууллага болон эмийн санг цахим жорын системд хамруулах, хамрагдсан байгууллагын гүйцэтгэлийн тайланг нэгтгэн жил бүрийн 01 дүгээр сарын 15, 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлнэ.

Найм. Эмийн сангийн эрх, үүрэг

8.1 Эмийн сан цахим жороор үйлчлэхдээ Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015 стандартыг баримтална.

8.2 Эмийн сангийн жор баригч иргэний амбулаториор үйлчлүүлэгчдийн карт дахь хяналтын дугаар эсвэл регистрийн дугаарыг үндэслэн иргэний үнэмлэхтэй тулган баталгаажуулж эмийг олгоно.

8.3 Иргэнд эмийг олгохдоо эмийн нэр, тун хэлбэр, тоо хэмжээг цахим жорын системийн мэдээллийн дагуу олгоно.

8.4 Үзлэг хийлгэж жор бичүүлсэн иргэн өөрөө ирээгүй тохиолдолд иргэний үнэмлэхийг үндэслэн жорыг олгож болно.

8.5 Эмийн санг цахим жорын системд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийн тайланг нэгтгэн жил бүрийн 01 дүгээр сарын 15, 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлнэ.